

ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН
МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

Мандах Их Сургуулийн 2024-2025 оны хичээлийн “ШИНЭ ОЮУТНЫГ УГТАХ ӨДӨРЛӨГ” 2024.08.24-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа

Сургуулийн удирдлагууд, эрдэмтэн багш нарыг танилцуулж, зөвлөх багш нар шинэ оюутан хүлээн авсан уулзалтыг зохион байгууллаа. Чанарын удирдлага зохицуулалтын албаны дарга П.Болормаа сургуулийн талаар товч танилцуулга мэдээлэл хүргэлээ.

Оюутны холбооны дарга, “Мандах мазаалай” эмэгтэй шигшээ багийн тамирчин Санхүү менежментийн 4-р түвшний оюутан Г.Цэнд-Аюуш шинээр элсэн суралцаж буй дүү нартаа хандаж оюутны сэтгэгдлээ илэрхийллээ.

Шинэ оюутнуудаа төлөөлж ЭЕШ-д Математикийн хичээлээр 720 оноотойгоор Бизнесийн удирдлагын ангид элсэн суралцагч Б.Батцэцэг сэтгэгдлээ хэллээ.

Сургуульдаа шинээр элсэн суралцаж буй оюутнууддаа сургуулийн гадаад, дотоод орчин хэрэгжүүлж буй хөтөлбөр үйлчилгээний талаар бүрэн танилцуулж халуун дотноор шинэ оюутнуудаа угтан авлаа.



МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ШИНЭ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО

Мандах Их Сургуулийн 33 дахь удаагийн буюу 2024-2025 оны шинэ хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагаа ёслол төгөлдөр боллоо. Нээлтийн ёслолын үйл ажиллагааг Мандах их сургуулийн захирал, МУГБ, профессор Г.Нанжид нээж үг хэллээ. Эрдэмтэн багш, ажилчдадаа хичээлийн жилийн баяр хүргэж, оюутан суралцагчдадаа, сурлага хөдөлмөрийн өндөр амжилт хүслээ.

Хүндэт зочдоор

Монгол улсын гавьяат эдийн засагч, Бүртгэл шинжилгээний тэнхимийн зөвлөх профессор Ренчингийн Батжаргал

Монгол улсын гавьяат эдийн засагч, Бүртгэл шинжилгээний тэнхимийн зөвлөх доктор, профессор Гүнсэнгийн Алтанзаяа

Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Эдийн засаг бизнесийн тэнхимийн зөвлөх профессор Доржийн Бадарч

Монгол улсын гавьяат багш, Мэдээлэл технологийн сургуулийн зөвлөх профессор Шомбонгийн Оросоо нар уригдан оролцлоо.

Мандах Их Сургуулийн хувьд 140 гаруй эрдэмтэн багш, ажилтан 2500 гаруй оюутан, суралцагчидтайгаар хичээлийн шинэ жилээ угтаж байна.

ЭЕШ-ын оноогоор 2024-2025 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн “Шинэ элсэгчдийг дэмжих” тэтгэлэгт 70 оюутан хамрагдаж батламжаа гардан авлаа.



АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛИЙН 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургуулийн Ахисан Түвшний сургуулийн 2024-2025 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаа 2024 оны 09 сарын 14-ний өдөр зохион байгуулагдлаа.

Нээлтийн үйл ажиллагааны хүрээнд Мандах Их сургуулийн Ахисан Түвшний сургуулийн захирал, доктор, дэд профессор О.Бурмаа “Ахисан Түвшний сургуулийн танилцуулга”-ыг нийт магистрантууддаа танилцуулж, 2024-2025 оны хичээлийн жилд хийгдэх ажлуудыг онцлон мэндчилгээ дэвшүүлэв.

Мөн магистрантууддаа “Хувь хүний хөгжил ба орчин цагт шаардагдаж буй ур чадварууд” сэдвээр сургалт орсон. Ахисан түвшний сургуулийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан Ө.Мөнхзаяа шинээр элссэн магистрантуудад зориулж сургалтын үйл ажиллагаанд ашиглагдах систем болон платформуудын талаар танилцуулав.



БАГШ НАРЫН БАЯРЫГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Дэлхийн багш нарын 30 дахь, Монголын багш нарын 58 дахь, Мандах Их сургуулийн 33 дах удаагийн багш нарын баярын арга хэмжээг 2024 оны 09 сарын 29-ны өдөр ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлээ.

Уламжлал ёсоор 2023-2024 онд сургалт, эрдэм шинжилгээ, бүтээлч ажил үйлсээрээ хамт олноо манлайлсан шилдэг багш нараа тодруулан шагнаж урамшууллаа.

“Шилдэг багш” -аар Гадаад хэлний тэнхимийн эрхлэгч Т.Оюун-Эрдэнэ

“Шилдэг залуу багш” -аар Компьютерийн ухааны тэнхимийн багш Х.Сувд-Эрдэнэ

“Шилдэг судлаач багш” -аар Эдийн засаг, бизнесийн тэнхимийн багш доктор, профессор С.Цолмон

Дархан салбар сургуулийн “Шилдэг багш”-аар багш Б.Сайханцэцэг шагнагдлаа.

Боловсролын яам болон бусад байгууллагын шагналаар олон багш, ажилтнууд шагнагдлаа.



“JOB FAIR-2024” НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургууль ажил олгогчдын хүний нөөцийг бүрдүүлэхэд туслах, байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, оюутнуудыг танилцах болон мэргэжлийн дадлага хийлгэхэд зуучлах, төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой уламжлалт “JOB FAIR-2024” ажлын байрны нээлттэй өдөрлөгийг 2024.10.29-нд зохион байгууллаа. Энэ удаагийн арга хэмжээ өмнөх жилээс өргөн цар хүрээнд зохион байгуулагдаж ажил олгогч 48 байгууллага оролцлоо.



Энэ хичээлийн жилийн “Ажлын байрны нээлттэй өдөрлөг”-ийн арга хэмжээний нээлтэд Мандах Их Сургуулийн Сургалт эрхэлсэн проректор доктор, профессор Ч.Төрбадрах нээж үг хэллээ. Ахисан түвшний сургуулийн захирал доктор, дэд профессор О.Бурмаа, Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн захирал дэд, профессор Х.Нямбаяр нар оролцлоо. Тус өдөрлөгт үйлдвэрлэлийн дадлага хийх, төгсөөд ажиллах зорилготой Мандах Их Сургуулийн 3, 4 дүгээр түвшний оюутнууд идэвхтэй оролцож нээлттэй ажлын байрны ажил горилогчийн анкетыг нийт 350 оюутан бөглөсөн байна. Ажлын байранд суурилсан сургалт нь байгууллага, сургууль оюутны гурвалсан гэрээгээр хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь оюутан цалинтай дадлага хийж төгсөөд гэрээт байгууллагууддаа ажилдгаараа ихээхэн давуу талтай. Энэхүү хөтөлбөрийг сүүлийн 3 жил амжилттай хэрэгжүүлж байна.




"ЭЕРЭГ ХАНДЛАГА-ЭРҮҮЛ ОЮУТАН" УРИАН ДОР "ОЮУТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ" ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/480, А/739 дүгээр тушаал, Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/139 тоот тушаалуудыг үндэслэн

Мандах Их сургууль Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран “Эерэг хандлага-Эрүүл оюутан” уриан дор “Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх” үзлэг шинжилгээг зохион байгууллаа.



БГДЭМТ-өөс нарийн мэргэжлийн 10 эмч, зөөврийн рентген аппарат, зүрхний цахилгаан бичлэг, биеийн бүтэц хэмжигч төхөөрөмжтэй ирж 122 оюутанд 10-р сарын 30,31 болон 11-р сарын 1-ний өдрүүдэд А102 А103 тоотод Эрт илрүүлгийг амжилттай зохион байгууллаа.



“МЕХАНИК ИНЖЕНЕРЧЛЭЛ” ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ГАРДАН АВЛАА

Мандах Их Сургуулийн Инженер, Эдийн Засгийн Сургуулийн “Механик инженерчлэл” бакалаврын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн гэрчилгээг Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөс ёслол төгөлдөр гардуулан өглөө.

“Механик инженерчлэл” бакалаврын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжилсэн тухай гэрчилгээг Мандах Их Сургуулийн ректор профессор Г.Нанжид, Сургалт эрхэлсэн проректор, доктор, профессор Ч.Төрбадрах, Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн эрхлэгч, доктор Д.Түвшинжаргал нар нь хүрэлцэн очиж, гэрчилгээг хүндэтгэлтэйгээр хүлээн авлаа.



СШУИТ-ын хамт олон, инженерийн хичээлийн баг, хөтөлбөрийн дэд хорооны гишүүд, өөрийн үнэлгээний багийн гишүүд, шинжээчийн багийг ажиллах таатай нөхцөлөөр ханган ажилласан, магадлан итгэмжлэх процесст оролцсон нийт хамт олондоо талархал илэрхийлье.

ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Бүртгэл шинжилгээний тэнхимээс "ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ Х ХУРАЛ"-ыг 2024.11.21-нд амжилттай зохион байгуулагдлаа. 2-4-р түвшний нийт 24 оюутан 12 илтгэлээр оролцсоноос шагналт байруудад дараах илтгэлүүд шалгарлаа.

Тэргүүн байр	НББ-Банк 4-р түвшин	О.Намуунцэцэг	Ирээдүйд нягтлан бодох бүртгэлийн оюутнуудаас шаардагдах чадамжид суурилсан сургалтын арга зүйг тодорхойлох нь
Дэд байр	НББ-Аудит 4-р түвшин	Д.Ариунтуяа О.Уянгалиянуа	Компанийн ашгийн удирдлагыг тодорхойлох нь: Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын жишээн дээр
Гутгаар байр	НББ-Аудит 4-р түвшин	Б.Дөлгөөн Б.Солонго Ц.Нямсүрэн	Ашгийн удирдлага болон татварын удирдлагын хамаарал: Санхүүгийн хувьсагчдад
Тусгай байр	НББ-Татвар 4-р түвшин	Х.Оюунцэцэг	Хойшлогдсон татвар компанийн санхүүгийн гүйцэтгэлд нөлөөлөх нь



“АНГЛИ ХЭЛНИЙ УР ЧАДВАР”-ЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургуулийн НББ-ийн Сургуулийн ГХТ-ээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “English Competence and Performance in ESL” тэмцээн 2024 оны 11 сарын 19-22-ны өдрүүдэд 2 болон 3-р түвшний оюутнуудын дунд амжилттай болж өндөрлөлөө.

Тэмцээнд оюутнууд ганцаарчилсан хэлбэрээр нийт 4 даалгавар гүйцэтгэж, тэмцээний төрөл тус бүрээр эхний 3 байрт шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав. Үүнд:

1. Сонсох чадварын тэмцээн

1 байр-О. Эмүжин /НББАудит-2/

2 байр-Ч. Түшиг /ПХ-3/

3 байр-З. Хүслэн /ПХ-3/

1. Бичих чадварын тэмцээн

1 байр-Ч. Түшиг /ПХ-3/

2 байр-З. Хүслэн /ПХ-3/

3 байр-Б. Төгөлдөр /НБББ-3/

1. Унших чадварын тэмцээн

1 байр-Н. Намуун /НББАудит-2/

2 байр-Б. Мөнх-Ариун /СМ-3/

3 байр-Д. Төгөлдөр /ПХ-3/

1. Ярих чадварын тэмцээн

1 байр-Б. Мөнгөнчавхдас /НББТ-2/

2 байр-О. Орчлон /ПХ-3/

3 байр- Б. Төгөлдөр /НБББ-3/



БҮРТГЭЛ ШИНЖИЛГЭЭНИЙ ТЭНХИМЭЭС УЛАМЖЛАЛ БОЛГОН ЗОХИОН БАЙГУУЛДАГ "НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС ХИЧЭЭЛИЙН ОЛИМПИАД" БОЛОН "НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛИМПИАД" АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Нягтлан бодох бүртгэлийн сургууль, Бүртгэл шинжилгээний тэнхимээс уламжлал болгон зохион байгуулдаг "Нягтлан бодох бүртгэлийн үндэс хичээлийн олимпиад" болон "Нягтлан бодох бүртгэлийн олимпиад" 2024 оны 12-р сарын 11-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

"Нягтлан бодох бүртгэлийн үндэс хичээлийн олимпиад"-д Мандах Их Сургуулийн төв болон Дархан салбар сургуулийн нэгдүгээр түвшний 84 оюутан оролцож, топ 10 оюутан шалгарлаа.

Мөн "Нягтлан бодох бүртгэлийн олимпиад"-д төв болон салбар сургуулийн гурав, дөрөвдүгээр түвшний нийт 43 оюутан оролцож, топ 10 оюутан шалгарлаа.



Тус олимпиадыг ивээн тэтгэгч Мандах Их Сургуулийн 2002 оны төгсөгч, Сити Ойл ХХК-ийн захирал Д.Гантулга болон хамт олонд нь талархал илэрхийлье. Сити Ойл ХХК нь энэхүү олимпиадыг 14 дахь жилдээ тасралтгүй ивээн тэтгэж байгаа нь оюутнуудын бие даан суралцах идэвхийг нэмэгдүүлэх, оюутан залуусын хөгжил, боловсролд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг онцлон тэмдэглэмээр байна.

“НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ГАРДАН АВЛАА

Мандах Их Сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” бакалаврын хөтөлбөрийн 5 дахь удаагийн /2006, 2012, 2015, 2019, 2024/ магадлан итгэмжлэлийн гэрчилгээг Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөс ёслол төгөлдөр гардуулан өглөө.

“Нягтлан бодох бүртгэл” бакалаврын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжилсэн тухай гэрчилгээг Сургалт эрхэлсэн проректор, доктор, профессор Ч.Төрбадрах, Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн захирал дэд профессор Х.Нямбаяр, Бүртгэл шинжилгээний тэнхимийн эрхлэгч Ц.Одгарав нар хүндэтгэлтэйгээр хүлээн авлаа. Бүртгэл шинжилгээний тэнхимийн хамт олон, хөтөлбөрийн дэд хорооны гишүүд, өөрийн үнэлгээний багийн гишүүд, шинжээчийн багийг ажиллах таатай нөхцөлөөр ханган ажилласан, магадлан итгэмжлэх процесст оролцсон нийт хамт олондоо талархал илэрхийлье.



ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛЛАА

Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн докторант Цэмбэл овогтой Номин нь 2024 оны 12 сарын 25-ны өдөр Монгол улсын их сургуулийн Бизнесийн удирдлагын докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр “Хувь хүнд чиглэсэн онлайн зар сурталчилгааны үр нөлөөг тодорхойлох судалгаа” сэдвээр Бизнесийн удирдлагын ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгааллаа. Ц.Номин докторынхоо цаашдын эрдэм судлалын ажилд өндрөөс өндөр амжилт хүсье.



БАКАЛАВРЫН ЭЧНЭЭ БОЛОН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Мандах Их Сургуулийн бакалаврын эчнээ болон магистрын хөтөлбөрийн төгсөлтийн үйл ажиллагаа 2024 оны 12 сарын 26-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Ёслолын үйл ажиллагааг нээж мандах ИС-ийн ректор, гавьяат багш, профессор Г.Нанжид хөтөлбөрт хамрагдаж амжилттай суралцсан оюутнууд болон тухайн хөтөлбөрт хичээл заасан багш нарт баяр хүргэн, цаашдын ажил, хөдөлмөрт нь амжилт хүслээ. Үйл ажиллагаанд Мандах Их Сургуулийн удирдлага, Эрдмийн зөвлөлийн гишүүд оролцож, төгсөгчдөд амжилт хүсэж, диплом энгэрийн тэмдгийг гардуулж өглөө.

Энэ удаагийн төгсөлтөөр бакалаврын эчнээ хөтөлбөрийн 26 оюутан, Нягтлан бодох бүртгэл, Санхүү, Бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрөөр 41 магистрант, “Бизнес удирдлагын цогц мэдлэг олгох зэргийн бус сургалт”-аар 10 суралцагч төгслөө.



Гадаад хамтын ажиллагаа

“WORLD ACADEMIC SUMMIT-2024” ЧУУЛГАНД СУРГАЛТ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР Ч.ТӨРБАДРАХ ОРОЛЦОВ

Жил бүр “Times Higher Education” (THE) зүгээс “World Academic Summit ” – аар дэлхий нийтэд тулгараад байгаа сорилтууд, түүнийг даван гарах шийдэл, түүнчлэн хамтын ажиллагааг сайжруулах талаар их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, боловсролын салбарын нөлөө бүхий аж ахуй нэгжүүд анхаарч ажиллан, мэдээллээ хуваалцах уулзалтыг зохион байгуулдаг.

Энэ удаагийн Дэлхийн эрдэм шинжилгээний хурал нь Making a difference: The purpose of universities in a rapidly changing world’ буюу “Өөрчлөлтийг бүтээх нь: Хурдацтай өөрчлөгдөх ертөнцөд орших их сургуулиудын зорилго” сэдвийн дор хүмүүсийн амьдралд бодит өөрчлөлт авчрахад их сургуулиудын үзүүлэх нийгмийн үүрэг болон хариуцлага дээр голчлон анхаарч Английн Манчестерийн Их Сургууль дээр 2024 оны 10 р сарын 7 - ны өдрөөс 9-ний өдрүүдэд зохиогдсон байна. Тус хуралд Мандах их сургуулийн сургалт эрхэлсэн проректор Ч.Төрбадрах оролцлоо.



Times Higher Education – н гол үйл ажиллагааны чиглэл нь олон улсын их дээд сургуулиудыг тодорхой шалгуураар шаталж эрэмбэ олгодог. Эрэмбэлэхдээ сургах арга зүй, судалгааны ажил, олон улсад харагдах дүр төрх (багш оюутан солилцоо, хамтын ажиллагаа), салбарын ашиг орлого зэргийг авч хэлэлцдэг.

МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧ АНГЛИЙН “CHARTERED MANAGEMENT INSTITUTE”-Д АЙЛЧИЛЛАА

Мандах ИС-ийн сургалт эрхэлсэн проректор, профессор Ч. Төрбадрах 2024 оны 10 сарын 10-11-ний өдрүүдэд Англи улсын Лондон хотноо СМІ “Chartered Management Institute” байранд зочиллон, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцлоо. Хамтын ажиллагааны хүрээнд хоёр тал мэргэшсэн менежерийн эрх олгох сургалтыг зохион байгуулж, чадварлаг менежерүүдийг бэлтгэн гаргахаар ажиллаж байна. Энэ уулзалтыг Мандах ИС-ийн Англи улс дахь төлөөлөгч С.Оюун зохион байгуулж, СМІ “Chartered Management Institute” -ын олон улс хариуцсан захирал Zain Munir хүлээн авч уулзан институтийн үйл ажиллагаа танилцуулсан. Түүний нэг онцолсон зүйл бол Монгол улсаас анх удаа СМІ байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн сургууль бол Мандах Их Сургууль юм гэж хэлсэн явдал байлаа.



Уулзалтын үеэр талууд одоогийн оюутан бүртгэл, СМІ-ээр хүлээн зөвшөөрөгдсөн 5 мэргэжил, суралцагсадын тоо, гишүүнчлэл ба түүний бүртгэл, явцын талаар үр дүнг хэлэлцэв. Урт хугацаанд оюутны тоо нэмэх, хөтөлбөрийг өргөжүүлэх зэрэг төлөвлөгөөг тодруулан ярилцлаа. Одоогийн байдлаар Мандах их сургуулийн 500 оюутан тус институтын гишүүнчлэлээр бүртгүүлж, сургалтын цахим системд нэвтрэн сургалтын материалыг судлах, ашиглах болон богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтыг онлайнгаар авч боломжтой юм. Ингэснээр Мандах ИС-ийн суралцагчид төгсөхдөө тус институтийн гэрчилгээтэй төгсөх юм. Түүнчлэн айлчлалын чухал хэсэг бол СМІ-ийн сургалтын BBE training төвтэй танилцсан ба төвийн сургалтын үйл ажиллагаа, сургалтын цахим систем, түүний ашиглалт гэх мэт мэдээллийг сургалтын төвийн удирдлагууд /Phil Eddy болон Steve/ өглөө. Энэ хүрээнд эрх олгох сургалтанд хамрагдаж буй суралцагчдад хэрхэн сургалтанд хамрагдах, сургалтын ач холбогдол, суралцагчийн үр дүн, мэдлэг, чадвар, хандлагыг эзэмших талаар нарийвчилсан зөвлөгөө өгөх талаар ярилцлаа.

Шинээр суралцахаар элсэгчдэдээ цаашдын сурлага, хөдөлмөрт нь амжилт хүсээд ирээдүйн Монгол улсын хөгжилд дэвшилд хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД ОЛОН УЛСЫН ФОРУМД ОРОЛЦЛОО

БНСУ-ын Хансон их сургуулиас 2024 оны 11-р сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан “Global Hansung Forum 2024” олон улсын форумд Япон, Солонгос, Монгол, Хятад гэсэн 4 улсын төлөөлөгчид оролцлоо. Уг форумд Мандах Их Сургуулиас Сургалт эрхэлсэн проректор, доктор, профессор Ч.Төрбадрах, Мандах лицей ахлах сургуулийн захирал Р.Даваахүү, Сургалтын менежер А.Мөнхсайхан, ЭЗБТ-ийн ахлах багш, доктор /Ph.D/ Т.Ганхуяг, Сургалтын албаны ахлах ажилтан Ц.Отгонцэцэг, ГХТ-ийн ахлах багш Ш.Нандинцэцэг нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцлоо.



Энэхүү форум нь “Сургалт, эрдэм шинжилгээ- ажил олгогч- үйлдвэрлэл” сэдвийн дор явагдсан ба форумын үндсэн хэсэгт уригдан ирсэн гадаадын төлөөлөгчид панелистаар оролцон өөрсдийн сургууль болон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хэрхэн хамтран ажилладаг талаар илтгэл тавьж хэлэлцүүлж, сонирхсон асуултанд хариулж, санал бодлоо солилцлоо. Форумд Мандах Их Сургуулийн сургалт эрхэлсэн проректор, Доктор, профессор Ч.Төрбадрах, ЭЗБТ-ийн ахлах багш, Доктор /Ph.D/ Т.Ганхуяг нар “Ажлын байранд суурилсан сургалтыг хэрэгжүүлсэн байдал” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүллээ.

Оролцогч талууд цаашид сургалт үйлдвэрлэл, старт апыг хөгжүүлэх, инноваци нэвтрүүлэх тал дээр хамтран ажиллах боломжийг судлан, багш, оюутнууды оролцоог идэвхижүүлэх тал дээр ажиллахаар боллоо.

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ БНСУ-ЫН ХАНСОН ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

БНСУ-ын Хансон Их Сургууль болон Мандах Их Сургууль хооронд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагаа Хансон Их Сургуулийн хурлын танхимд зохион байгуулагдлаа.

Уг үйл ажиллагаанд Хансон Их Сургуулийн захирал, доктор, профессор Ли Чан Вон тэргүүтэй албаны хүмүүс болон Мандах Их Сургуулийн сургалт эрхэлсэн проректор, доктор, профессор Ч.Төрбадрах тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Хансон их сургуулийн удирдлага, эрдэмтэн профессорууд манай сургуулийн төлөөлөгчдийг найрсагаар хүлээн авч, албан ёсны уулзалт хийж, цаашид хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар харилцан санал солилцлоо. Тус санамж бичигт дараах хамтын ажиллагааг тусгав. Үүнд:

- Оюутан солилцоо
- Багш, ажилтан солилцоо
- Хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааны ажил
- Богино хугацааны сургалт
- Хос хөтөлбөр
- Мандах Лицей ахлах сургуулийн сурагчдын танилцах аялал

Түүнчлэн Хансон их сургуульд “Мандах-2025” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцох Мандах Их Сургуулийн Ректор Г. Нанжидын урилгыг гардуулан өглөө. Тус сургуулиас Мандах-2025 хуралд оролцохоо илэрхийлсэн.

Гарын үсэг зурах үйл ажиллагаанд Мандах лицей ахлах сургуулийн захирал Р.Даваахүү, сургалтын менежер А.Мөнхсайхан, ЭЗБТ-ийн ахлах багш, Доктор /Ph.D/ Т.Ганхуяг, СА-ны ахлах ажилтан Ц.Отгонцэцэг, ГХТ-ийн ахлах багш Ш.Нандинцэцэг байлцлаа.



МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД БНСУ-ЫН САНМЁН ИХ СУРГУУЛЬД АЙЛЧИЛЛАА

БНСУ-ын Санмён Их Сургууль болон Мандах Их Сургууль хооронд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд тус сургуулийн төлөөлөгчтэй албан ёсны уулзалт хийлээ. Уг үйл ажиллагаанд Санмён Их Сургуулийн гадаад харилцааны албаны дарга Хун Ён Жүнь тэргүүтэй албаны хүмүүс болон Мандах Их Сургуулийн Сургалт эрхэлсэн проректор, доктор, профессор Ч.Төрбадрах тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо.

с уулзалтаар санамж бичигт тусгагдсан хамтын ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар санал солилцон, тодорхой шийдэлд хүрлээ. Үүнд:

- Бизнесийн удирдлага хөтөлбөрийн 2+2 хамтарсан хөтөлбөрийн гэрээг батлах
 - Инженерийн бакалаврын хөтөлбөрүүдэд 2+2 хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх
 - Мандах Их Сургуулийн оюутнууд болон ахлах сургуулийн сурагчдад зориулсан тэтгэлэг олгох / солонгос хэлний сургалт, оюутны байрны төлбөр, сургалтын төлбөр/
 - Мандах Лицей ахлах сургуулийн сурагчдын танилцах аялал хийх
- Санмён сургуулийн солонгос хэлний багш сургалт явуулах

Түүнчлэн Санмён их сургуульд “Мандах-2025” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцох Мандах Их Сургуулийн ректор Г. Нанжидын урилгыг гардуулан өглөө.

Уулзалтанд Мандах лицей ахлах сургуулийн захирал Р.Даваахүү, сургалтын менежер А.Мөнхсайхан, ЭЗБТ-ийн ахлах багш, Доктор /Ph.D/ Т.Ганхуяг, СА-ны ахлах ажилтан Ц.Отгонцэцэг, ГХТ-ийн ахлах багш Ш.Нандинцэцэг байлцлаа.



БНСУ-ЫН ХАЛЛА ИХ СУРГУУЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД МАНДАХ ИХ СУРГУУЛЬД АЙЛЧИЛЛАА

Мандах их сургуулийн төв байранд БНСУ-ын Халла их сургуулийн зочид төлөөлөгчид ирж, Мандах их сургуулийн удирдлагатай уулзан, хоёр талаас сургалт, судалгааны чиглэлээр хамтран ажиллах чиглэлээ тодорхойлов.

Уг үйл ажиллагаанд Халла их сургуулийн захирал доктор, профессор Ким Иун Гвон тэргүүтэй албаны хүмүүс болон Мандах Их Сургуулийн ректор, профессор Г.Нанжид тэргүүтэй




Halla university нь 1995 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Сөүл хотоос 140 км – н зайд, Вонжу (Wonju) хотод байрладаг. Тус сургууль нь Hyundai International – н салбар HL group – н охин компани юм.

Талууд 3+1 хөтөлбөрийг цахилгаан инженер болон механик инженер мэргэжлээр хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар болов.

МАНДАХ ИХ СУРГУУЛЬ УЛСЫН 2-Р ТӨВ ЭМНЭЛЭГТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАВ

Мандах их сургууль болон Улсын 2-р төв эмнэлэг хамтран нэгнээ түшиглэж хамтын ажиллагаагаа хөгжүүлэх ажлын хүрээнд уулзлаа.

Мандах их сургууль нь Улсын 2-р төв эмнэлэгтэй хамтран сургалт судалгаа, шинжилгээний ажил хийх, оюутан дадлагажуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах зэрэг тус тус чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцож, түншлэлийн гэрээ байгуулав.



Уг үйл ажиллагаанд Улсын 2-р төв эмнэлгийн ерөнхий захирал Б.Бямбадорж, эмзүй хариуцсан дэд захирал Ц.Ганзориг, эрдэм шинжилгээ, инновац, хөгжлийн бодлого хариуцсан дэд захирал Д.Цогт-очир мөн Мандах Их Сургуулийн ректор, профессор Г.Нанжид, Сургалт эрхэлсэн проректор Ч.Төрбадрах, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан Б.Чинбат байлцлаа.

Шагнал урамшуулал

АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР О.БУРМАА “АЛТАН ГАДАС ОДОНГООР ШАГНУУЛЛАА

Мандах Их Сургуулийн, Ахисан түвшний сургуулийн захирал доктор, дэд профессор О.Бурмаа Дэлхийн багш нарын 30 дахь, Монголын багш нарын 58 дахь удаагийн багш нарын баярыг тохиолдуулан төрийн дээд шагнал “АЛТАН ГАДАС” одонгоор шагнагдаж, хийж бүтээсэн ажил, хөдөлмөрөө төрөөр үнэлүүллээ.



Сургуулийн хамт олны зүгээс цаашдын сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд өндөр амжилт хүсье.

СУРГУУЛИЙН ЗАХИРГАА

Шагнал урамшуулал

ИРЭЭДҮЙН АУДИТОРУУДЫН СОРИЛГО 2024” ОЛИМПИАД 4 ДЭХ ЖИЛДЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

“Грант Торнтон Аудит” ХХК-аас санаачлан уламжлал болгон их, дээд сургуулиудын оюутнуудыг хамруулан зохион байгуулдаг “Ирээдүйн аудиторуудын сорилго 2024” олимпиад 4 дэх жилдээ зохион байгуулагдаж Мандах Их Сургуулийн багш, оюутнууд амжилттай оролцож дараах шагналт байранд шалгарлаа. БШТ-ийн Ахлах багш М.Энхсүрэн, багш Г.Энх-Отгон, С.Цэвээнжаргал нар удирдагч багшаар ажиллаж амжилт гаргасанд баяр хүргэе.

Шилдэг оюутан:

2-р байр: Мандах Их Сургуулийн оюутан Б.Булган-Эрдэнэ, Х.Цолмон-Эрдэнэ нар оноо тэнцэж дэд байранд шалгарлаа.

- ◆ Шилдэг илтгэл:

Мандах Их Сургуулийн "Mandakh Aces" баг

- ◆ Шилдэг баг:

Гутгаар байр: Мандах Их Сургуулийн "Mandakh Rangers" баг

- ◆ Шилдэг багш:



“ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГ ХАНДЛАГА 2024” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага үүсч хөгжсөний 27 жилийн ойн хүрээнд доктор профессор, тэргүүлэх үнэлгээчин С. Доржсүрэн багшийн нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг илтгэл, бүтээлийг шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурал нь 2024 оны 11 сарын 15-29-ний хооронд 2 үе шаттайгаар ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль дээр амжилттай зохион байгуулагдлаа.



Энэхүү хуралд нийт 30 орчим илтгэл хэлэлцүүлэхээр ирснээс судлаач ангилалд ЭЗБТ-ийн профессор, доктор С. Цолмон, багш Г. Эрдэнэцогт, А.Тамир нарын “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд машин сургалтын алгоритм ашиглах нь”, оюутан ангилалд НББ-Статистик 4-р дамжааны оюутан Б. Азбилэг, Б. Дэлгэрзаяа, Г. Номин-Эрдэнэ (удирдагч багш БШТ-ийн дэд профессор, доктор А.Наранцэцэг) нарын “Үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдаа, түүний үнэлгээ” сэдэвт бүтээлүүд тус бүр 2-р байранд шалгарч, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа.

МАНДАХ ИХ СУРГУУЛИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ Б.САНДАГСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ СПОРТЫН 4 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН АМЖИЛТТАЙ БОЛЛОО

Мандах Их Сургуулийн үүсгэн байгуулагч Б. Сандагсүрэнгийн нэрэмжит сургуулийн аварга шалгаруулах уламжлалт спорт тэмцээн 2024 оны 11 сарын 04 нээс 11-р сарын 18-ны өдөр хүртэл амжилттай болж өндөрлөлөө. Сургуулийн аварга шалгаруулах энэхүү тэмцээнийг 1997 оноос хойш уламжлал болгон зохион байгуулж ирсэн бөгөөд сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар гэсэн 4 төрөлт тэмцээн болон өргөжиж, тамирчдын чансаа ч улам сайжирч байна. 2018 онд 32 баг оролцож байсан бол энэ жилийн тэмцээнд нийт 70 баг тамирчид хоёр долоо хоногийн турш өрсөлдөж өнөөдөр нэгдсэн дүнгээ гаргаж, аваргуудаа тодрууллаа.

Нэгдсэн дүнгээр

- НББ-Аудит хөтөлбөр
- НББ-1-3 түвшин
- Санхүү, банк хөтөлбөр



АВЬЯАСЛАГ МАНДАХЧУУД

1-р түвшний оюутнуудын дунд жил бүр зохион байгуулагддаг уламжлалт “Оюутны урлагийн наадам” 2024 оны 10 сарын 26-ны өдөр “Төмөр зам палас”-д амжилттай болж өндөрлөлөө.

Шилдгээр:

Хамтлаг дууны төрөлд:

Санхүү банк хөтөлбөрийн 1-р түвшний үзүүлбэр

Цэнгээнт бүжгийн төрөлд:

Бизнесийн удирдлага, маркетинг менежмент хөтөлбөрийн

1- түвшний үзүүлбэр

Flash mob төрөлд:

Программ хангамж, 1-р түвшний үзүүлбэр тус тус шалгарлаа.

Урлагийн наадамд 7 хөтөлбөрийн оюутнууд авьяасаа сорьсноос:

- * I байрт 73,8 оноогоор Бизнесийн удирдлага, маркетинг менежмент 1-р түвшин
- * II байрт 68,9 оноогоор Санхүү менежмент 1-р түвшин
- * III -байрт 65,1 Нягтлан бодох бүртгэл -3 хэсэг 1-р түвшний хамт олон тус тус шалгарлаа.



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах /Сургалт эрхэлсэн проректор /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

Г.Энхжин/ Санхүү аж,ахуйн алба/
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn